

***СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН, ОНЦЛОГ ШИНЖ ЧАНАР  
СУРАЛЦАГЧДЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ НЬ***

***MEETING THE NEEDS OF STUDENTS WITH THE CURRICULUM'S  
CHARACTERISTICS***

**Б.Үүрцайх**

ДХИС-ийн магистрант, ахлах дэслэгч

**Хураангуй:** Дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт, 2010-2021 баримт бичигт: “дээд боловсролын чанарын баталгаажуулалт, сургалт, эрдэм шинэилгээний стандарт, агуулгын шинэчлэлийн бодлогын стратегийн зорилтыг дээд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох, гэж онцлоод түүний хүрээнд: олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, судалгааны чиглэлийг нийгмийн хэрэгцээ, шаардалагад нийцүүлэн боловсронгуй болгох, гэж онцлоод түүний хүрээнд, олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох, зорилт нь дээд боловсролын чанарыг дээшлүүлэх, олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, цаашлаад манай улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлыг тухайлан чухалчлан авч үзлээ.

**Abstract:** The Higher Education Development Policy Objectives, 2010-2021 document: “The strategic objectives of the policy for quality assurance, training, research and innovation standards, and content innovation in higher education are to establish higher education standards, curricula, and plans, and within this framework: to develop curricula and research areas that meet international standards in accordance with social needs and requirements, and within this framework, to establish curricula and plans that meet international standards, and the objectives are to improve the quality of higher education, increase accountability to the public, and further enhance the competitiveness of our country.”

**Түлхүүр үг:** Сургалтын хөтөлбөр, боловсрол, суралцахуйн үр дүн, сургах арга зүй, үнэлгээний арга зүй, хэрэглэгдэхүүн, сургалтын төлөвлөгөө, онол практик

**Keywords:** Curriculum, education, learning outcomes, teaching methodology, assessment methodology, materials, curriculum, theory and practice

## Үндсэн хэсэг

Curriculum буюу сургалтын хөтөлбөр гэдэг нь тодорхой түвшний боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, сурах, сургах арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний арга зүй, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм.

Урьд нь бид сургалтын хөтөлбөр гэдэг ойлголтыг олон улсын жишгээр оновчтой тодорхойлж чадахгүй, сургалтын төлөвлөгөөтэй андууран агуулгыг нь багасгаж хичээлийн нэр, багц цаг, код, заагдах улирал зэргийг багтаасан 2-3 нүүр бичиг баримт мэт үзэх эсвэл агуулгыг нь ихэсгэн олон шаардлагагүй зүйлсийг нэмж авч үзэх гэх мэт алдааг гаргадаг байсан. Иймээс Үр Дүнд Суурилсан Боловсрол(ҮДСБ)-ын тогтолцоонд сургалтын хөтөлбөрийг олон улсын жишгээр хэрхэн тодорхойлсныг сургалтын хөтөлбөр боловсруулах ажил эхэлнэ.

Орчин үеийн дээд боловсролын чиг хандлагын дагуу сургалтын хөтөлбөр нь дараах шинж чанарыг хангасан байх ёстой. Үүнд:

- Суралцахуйн үр дүнгийн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх
- Онол практикийг хослуулсан байх
- Суралцагчийн хувь хүний болон мэргэжлийн чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байх
- Сургалтын арга зүй, сургалтын үнэлгээний хэлбэр, суралцахуйн үр дүнг, бүрэн багтаасан байх
- Оролцогч талуудын санал зөвлөмжийг тусган байнга сайжруулалт хийдэг байх,
- Хичээл хоорондын уялдаа, холбоог хангасан байх гэх мэт.

Олон улсад мөрдөж байгаа нийтлэг жишгээр сургалтын хөтөлбөр нь зураг 1.1-д үзүүлсэн бүрэлдэхүүн хэсэгтэй ба эдгээрийг товчхон тайлбарлая.



Зураг 1.1. Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг

**Хөтөлбөрийн Боловсролын Зорилт (PEO):** Хөтөлбөрийн боловсролын зорилт нь тухайн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчид суралцаж байх үедээ олж авсан мэдлэг, ур чадвартаа тулгуурлан, мэргэжлээрээ 4-5 жил ажилласны дараа хэрхэн хөгжиж, чадамжийн хувьд ямар түвшинд хүрсэн байх ёстойг илэрхийлнэ. Их сургуулийн стратеги төлөвлөгөө, эрхэм зорилго, ажил олгогчдын судалгаанд үндэслэн хөтөлбөрийн зорилтыг томъёолно.

**Хөтөлбөрийн Суралцахуйн Үр Дүн (PLO):** Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн сургууль төгсөх үедээ эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт болон түүний түвшинг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, оюутан төгсөх үедээ юу мэддэг, ямар ур чадвартай, аливаад хэрхэн ханддаг болсон байхыг илэрхийлэх үр дүн гэж ойлгож болно.

**Сургалтын төлөвлөгөө** нь судлах хичээлийн нэр, код, ангилал, улирал, багц цаг, зохион байгуулалт (хичээлийн хэлбэр, залгамж холбоо, цагийн задаргаа, сонгох боломж)-ыг тодорхойлсон хэсэг бөгөөд сургалтын төлөвлөгөө гэж нэрлэгддэг.

Сургалтын төлөвлөгөөнд багтсан хичээлүүд нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдан тодорхойлогдохоос гадна, багц цагийн хуваарилалт нь дотоод, гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагын шалгуур, шаардлага болон боловсролын асуудал хариуцсан яамны дүрэм, журмуудтай нийцүүлэн тогтоогддог. Жишээлбэл, олон улсын магадлан итгэмжлэлийн АВЕТ байгууллагаар магадлан итгэмжлэгдэх инженерийн чиглэлийн сургалтын хөтөлбөрт, математик болон суурь шинжлэх ухааны чиглэлийн хичээлүүд нийт хичээлийн багц цагийн дор хаяж 25 хувийг эзлэх ёстой гэж заасан байдаг. Мөн Монгол Улсын аль ч их, дээд сургуульд Монголын түүх, Хүний хөгжил зэрэг хичээлийг заавал судлах шаардлагатай байдаг.

### **Хичээл ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарал:**

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлдог бөгөөд эдгээрийг сургалтын төлөвлөгөөнд багтсан ямар хичээлүүдээр дамжуулан эзэмших боломжтойг харуулсан матрицыг хичээл ба суралцахуйн үр дүнгийн хамаарлын матриц гэж нэрлэдэг. Үндэсний дээд боловсролын стандартын (ҮДСБ) тогтолцоог бодитоор хэрэгжүүлэхийн тулд зөвхөн сургалтын төлөвлөгөөг боловсруулах нь хангалтгүй бөгөөд хөтөлбөрийн хичээлүүд ба суралцахуйн үр дүнг хооронд нь уялдуулсан матрицыг сайтар боловсруулах шаардлагатай. Хэдийгээр суралцахуйн үр дүнг тодорхой тусгасан байлаа ч, хэрэв энэ матриц бүрэн гүйцэд боловсруулахгүй бол суралцахуйн үр дүн нь зөвхөн нэр төдий зүйл болон хувирах эрсдэлтэй.

Тиймээс олон улсын жишгийн дагуу сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн бүрийг сургалтын төлөвлөгөөнд багтсан ямар хичээлүүдээр эзэмшихийг тодорхойлсон дээрх матрицыг заавал боловсруулах шаардлагатай. Энэ матриц нь хичээл тус бүрийн оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлон харуулдаг бөгөөд сургалтын чанарыг баталгаажуулах, суралцахуйн үр дүнг бодитой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

**Хичээлийн хөтөлбөр гэдэг нь** тухайн хичээлийн ерөнхий мэдээллээс гадна сургалтын зорилго, хүрэх үр дүн, ерөнхий агуулга, сургах, суралцах үйл ажиллагааны хэлбэр, үнэлэх арга зүй зэрэг мэдээллийг багтаасан баримт бичиг юм.

Хичээлийн хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хичээлүүдийг зөв төлөвлөх, улмаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг оюутанд бүрэн эзэмшүүлэх гол үндэс болдог.

Уламжлалт сургалтын хөтөлбөрийн хувьд хичээлийн хөтөлбөр нь зөвхөн тухайн хичээлээр заагдах агуулгад голчлон төвлөрдөг. Харин ҮДСБ-ын тогтолцоонд суурилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд хичээлийн хөтөлбөрт агуулгаас гадна тухайн хичээлээр эзэмших Хичээлийн Суралцахуйн Үр Дүн (CLO), заах арга зүй, хүргэх хэлбэрүүд, үнэлгээний аргууд зэрэг багтаж, эдгээрийг бүлэг сэдэв бүрт тодорхойлон тусгах шаардлагатай.

### **Сургалт явуулах сурган заах арга зүй, хүргэх хэлбэр:**

Заах арга зүй буюу "Pedagogy" гэсэн ойлголт нь "хүүхдийг сургахуй" гэсэн утгатай "paidagogos" гэх грек үгнээс үүсэлтэй. Орчин үеийн боловсролын шинжлэх ухаанд энэ ойлголтыг тухайн заах мэдлэг, үйлийн төрөл, онцлогтой уялдуулан, түүнийг бусдад үр бүтээлтэй заах тогтсон дүрэм, журам гэж тодорхойлдог бөгөөд үүнийг "Pedagogy" буюу заах арга зүй гэж нэрлэдэг.

Орчин үед уламжлалт сургалтын аргуудаас гадна идэвхтэй сургалтын олон шинэ аргууд өргөн хэрэглэгдэх болсон. Идэвхтэй сургалтын арга барилыг ашигласнаар суралцахуйн үр дүн нэмэгдэж, шинэ зууны суралцагчдын сэтгэл зүйн онцлогт илүү тохиромжтой болдог. Тиймээс сургалтын хөтөлбөрийн онцлогт тохирсон заах арга зүй болон хүргэх хэлбэрийг сургалтын хөтөлбөрийн баримт бичигт тодорхой тусган, багш нарт санал болгох нь түгээмэл жишиг болсон. Хүргэх хэлбэр гэдэг нь тухайн заах арга зүйн хүрээнд хичээлийн суралцахуйн үр дүнг оюутанд олгохын тулд сургалтын процессыг дэмжих, идэвхжүүлэх зорилготой, хичээл явуулах оновчтой арга хэлбэрийг хэлнэ. Лекц, семинар зэрэг нь хүргэх хэлбэрийн жишээ юм.

Жишээлбэл, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхийн тулд асуудалд суурилсан сургалтын арга зүйг ашиглаж байгаа тохиолдолд тухайн хичээлийг семинар хэлбэрээр явуулах нь илүү үр дүнтэй байж болно. Иймээс хичээлийн суралцахуйн үр дүн, заах арга зүй, хүргэх хэлбэрийг тухайн хичээлд тохируулан оновчтой төлөвлөх шаардлагатай.

### **Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, тасралтгүй сайжруулалт**

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ гэдэг нь оюутан хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хэр зэрэг эзэмшсэнийг тодорхойлох зорилготой хичээл болон сургалтын хөтөлбөрийн түвшинд хийгдэх үнэлгээ юм.

Гамшгийн эрсдэл судлал \_\_\_\_\_

Тогтмол үнэлгээ хийхийн давуу талууд:

- ✓ Оюутны эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг хөтөлбөрийн хүрээнд оновчтой тодорхойлох боломжтой.
- ✓ Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээнд тулгуурлан сургалтын хөтөлбөр болон хичээлийг тасралтгүй сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Үнэлгээний үр дүнг ашигласнаар сургалтын чанарыг дээшлүүлэх, суралцагчдад үр өгөөжтэй сургалтын орчин бүрдүүлэх боломжтой.

- ✓ Хөтөлбөрт шаардлагатай шинэ хичээл нэмэх,
- ✓ Хичээл хоорондын уялдааг сайжруулах,
- ✓ Сургалтын хөтөлбөрийг илүү нийцтэй, үр дүнтэй болгох боломж бүрдэнэ.

Хэрэв хөтөлбөрийн суралцахуйн үр дүн зорилтот түвшинд хүрээгүй эсвэл үнэлгээний үр дүнгийн үзүүлэлт буурсан тохиолдолд үүнд нөлөөлсөн шалтгаануудыг тогтоон, засах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл явцыг сургалтын хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалт гэж нэрлэнэ.

Энэхүү тасралтгүй сайжруулалт нь сургалтын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, оюутны суралцах үйл явцыг илүү үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтой.

Хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалт ба чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтыг тухайн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын гол үндэс гэж үзэж болно.

✓ Сайжруулалттай холбоотой баримт, нотолгоог цаг тухайд нь бүрдүүлж, албан ёсны тайлангийн баримт бичиг болгон хадгалах тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай.

✓ Суралцахуйн үр дүнгийн шатлалд тохируулан сайжруулалтын давтамжийг төлөвлөнө.

Жишээ нь:

✦ Хичээлийн түвшний суралцахуйн үр дүн (CLOs)-д суурилсан үнэлгээний үр дүнгээр сайжруулалт хийх бол улирал тутамд хийнэ.

✦ Хөтөлбөрийн түвшний суралцахуйн үр дүн (PLOs)-д суурилсан сайжруулалтыг жил тутамд төлөвлөнө.

Энэхүү тогтолцоо нь хөтөлбөрийн чанарыг тогтвортой хадгалах, боловсролын түвшинг тасралтгүй сайжруулах үндэс суурь болдог.

### **Нийлмэл сургалтын хөтөлбөрийн онцлог шинж**

Орчин үед "нийлмэл" гэсэн нэр томъёог сургалтын хөтөлбөрт ашиглаж байгаа бөгөөд энэ нь дараах байдлаар тодорхойлогдоно.

- ✓ Суралцагчдад тухайн салбар чиглэлийн мэдлэгээс гадна
- ✓ Хувь хүний болон хувь хүн хоорондын харилцааны ур чадвар
- ✓ Бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагаа бий болгох ур чадвар

Эдгээрийг харилцан уялдаатай хичээлүүдээр олгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрийг "нийлмэл сургалтын хөтөлбөр" гэж нэрлэдэг.

Энэхүү хөтөлбөр нь оюутнуудад мэргэжлийн мэдлэгээс гадна практик ур чадвар, багаар ажиллах болон асуудал шийдвэрлэх чадамжийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

**Нийлмэл сургалтын хөтөлбөрийн онцлог шинж:** Нийлмэл сургалтын хөтөлбөр нь дээр дурьдсан ҮДСБ-ын тогтолцоо бүхий сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг агуулах боловч дараах онцлог шинжтэй. Үүнд:

- a. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн жагсаалтад хувь хүний, хувь хүн хоорондын харилцааны болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадварыг заавал багтаасан байна;
- b. Тухайн хөтөлбөрт байгаа хичээл бүрийн суралцахуйн үр дүнд мэдлэгээс гадна ур чадвар, хандлага олгох үр дүнг заавал тусгасан байна;
- c. Тухайн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, мэргэжлийн чиглэлийн онцлогт нийцэх сурган заах арга зүйн үр дүнтэй, шинэлэг арга, хэлбэрийг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан багш нарт санал болгодог байна;
- d. Сургалтын төлөвлөгөөнд хувь хүний, хувь хүн хоорондын харилцаа болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадвар олгох тусгайлсан төслийн хичээлийг (3-4 хичээл) заавал багтаасан байна;

- e. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ болон тасралтгүй сайжруулалтыг хийх төлөвлөгөөг сургалтын хөтөлбөрийн баримт бичигт заавал багтааж хэрэгжүүлдэг байна;
- f. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад төгсөгчид, багшлах бүрэлдэхүүн, ажил олгогчид, хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөл зэрэг талуудыг заавал оролцуулдаг байна.

***Эдгээр онцлог шинжийг тус бүрд нь товч тайлбарлая.***

- a. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн талаас нь авч үзвэл суралцагчид зөвхөн мэдлэг эзэмших бус мэдлэгээ хэрэглэх ур чадвартай болгох үүднээс суралцахуйн үр дүнд гол гол практик ур чадвараас гадна хувь хүний болон харилцааны ур чадвар, хандлагыг багтаасан байх ёстой. Ингэснээр цогц чадамж буюу суралцахуйн үр дүнгийн хувьд нийлмэл шинж чанарыг агуулж чадна. Тухайлбал CDIO стандарт, арга зүйн хувьд нийлмэл сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг томъёолоход ашиглах боломжтой мэдлэг, ур чадвар, хандлагыг илэрхийлэх суралцахуйн үр дүнгийн жишиг загварыг CDIO загварын 2-р стандартын дагуу тодорхойлсон байдаг. Зураг 1.2-д үзүүлснээр CDIO стандарт, арга зүй нэвтрүүлсэн хөтөлбөрөөр суралцагч нь тухайн салбар чиглэлийн мэдлэг эзэмшихээс гадна хувь хүн талаасаа хөгжих, нийгэмших, мөн аливааг бүтээх зэрэг ур чадвар, хандлагыг цогцоор нь эзэмших боломжтойгоор суралцахуйн үр дүнг тодорхойлсон байдаг.





**Зураг 1.2. Нийлмэл сургалтын хөтөлбөрөөр суралцагч оюутны эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагын цогц**

- b. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд зөвхөн мэдлэг бус төгсөгчдөд шаардлагатай ур чадвар, хандлага багтсан байх ба эдгээрийг оюутан заавал эзэмшиж төгсөх ёстой. Сургалтын хугацаа, тэнд багтсан хичээлүүдийн багц цагийн хуваарилалт, агуулгын багтаамжаас хамаарч ур чадвар, хандлага талын үр дүнг тусгайлсан хичээлээр олгох боломж багатай учраас хичээл бүрд суралцахуйн үр дүнг зөв хуваарилах замаар энэ асуудлыг шийдэх боломжтой. Өөрөөр хэлбэл хичээл зааж байгаа багш бүр тухайн хичээлийн агуулгын дагуу тодорхой мэдлэг олгохоос гадна тэр мэдлэгийг олон нөхцөлд хэрэглэх ур чадвар, мөн хувь хүний болон харилцааны ур чадвар, хандлага олгоход хичээлийн суралцахуйн үр дүнг чиглүүлэх ёстой.

Тухайн хичээлээр оюутны эзэмших суралцахуйн үр дүн нь нийлмэл буюу мэдлэг, ур чадвар, хандлагаас тогтох учраас тухайн хөтөлбөрийн онцлогт тохирсон, орчин үеийн оюутнуудын сэтгэл зүйд нийцэх, тэднийг идэвхжүүлэх сурган заах арга зүйн үр дүнтэй, шинэлэг арга, хэлбэрийг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан багш нарт санал болгож, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байх ёстой.

с. Төслийн хичээлийг сургалтын төлөвлөгөөнд заавал багтааснаар оюутан салангид хичээлүүдээр олж авсан онолын мэдлэг болон мэргэжлийн ур чадварыг нэг хичээл дээр том хэмжээний төсөл, асуудал шийдвэрлэх даалгавар гүйцэтгэж бататгах, тэдгээр мэдлэг, ур чадвараа хооронд нь холбож гүн гүнзгий ойлгох, хэрэглэж сурах, хажуугаар нь бичгийн болон аман харилцааны ур чадвартай болох гэх мэтээр нийлмэл сургалтын хөтөлбөрийн олон талт суралцахуйн үр дүнг бүрэн эзэмших боломж бүрддэг. Олон улсад нийлмэл сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй жишгээр оюутан элссэн эхний жил мэргэжлийн удиртгал хичээлийг заавал судалдаг ба ингэснээр шинэ элсэгчид мэргэжлээ гүн, гүнзгий ойлгох, мэргэжилдээ дурлах, тодорхой бүтээлч даалгаварыг багаар гүйцэтгэн бүтээлч, багаар ажиллах сэтгэхүйтэй болж эхлэх, өөрийн мэргэжлийн онцлогыг ойлгох, мэргэжлийнхээ ёс зүйг ухамсарлах зэрэг ур чадвар, хандлагыг эзэмшдэг. Энэ хичээлийн залгамж болгож хэд хэдэн төслийн хичээлийг хөтөлбөрт суулгаж өгснөөр олон талт суралцахуйн үр дүнг оюутанд эзэмшүүлэх боломж бүрддэг. CDIO стандарт, арга зүйн хувьд нийлмэл сургалтын хөтөлбөрт төслийн хичээлүүдийг тусгах, хэрэгжүүлэх боломжийг 4(Инженерийн удиртгал), 5(Зохион бүтээх төслийн хичээлүүд), 6(Инженерийн урлан) стандартаар тус тус тодорхойлж өгсөн байдаг.

d. Нийлмэл сургалтын хөтөлбөрийн дараагийн чухал онцлог нь сургалтын хөтөлбөрийн үнэлгээ болон тасралтгүй сайжруулалт хийх төлөвлөгөөг сургалтын хөтөлбөрийн баримт бичигт тусган хэрэгжүүлдэг ба ингэснээр хөтөлбөрөөр төгсөн гарах төгсөгчдийн чанарыг үнэлэх, сайжруулах механизм бүрддэг. Хөтөлбөрийн үнэлгээ болон тасралтгүй сайжруулалт хийх төлөвлөгөөнд сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээг аль аль түвшинд, ямар аргуудаар, ямар хугацааны давтамжтайгаар хийх, тухайн үнэлгээ тус бүрийг хэрхэн зохион байгуулах, боловсруулах, хэрэгжүүлэх талын мэдээллийг дэлгэрэнгүй тусгадаг. CDIO стандарт, арга зүйн 11, 12-р стандартыг хэрэгжүүлснээр сургалтын хөтөлбөрийн бүх шатанд чанарын үнэлгээ хийх, тасралтгүй сайжруулах боломж бүрддэг.

e. Сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд төгсөгчид, багшлах бүрэлдэхүүн, ажил олгогчид, хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөл зэрэг гол гол талыг татан оролцуулснаар сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг оновчтой тодорхойлох, улмаар төгсөгчдийн чанарт бодит үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашлаад сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлтийг цаг алдалгүй оновчтой хийх зэрэг давуу тал бий болдог.

f. Сургалтын хөтөлбөрийн нийлмэл шинж чанарыг илэрхийлэх хамгийн гол үзүүлэлт бол оюутны эзэмших суралцахуйн үр дүн талаасаа хөтөлбөрт байгаа

хичээлүүд өөр хоорондоо нягт уялдаатай байхаас гадна мэдлэгийг ур чадвар болгох цөм хичээл, төслийн хичээлийг хэрэгтэй цагт нь судлах боломж бүрдсэн байх ёстой.


Уламжлалт сургалтын хөтөлбөрийн бүтэц, төлөвлөлтийг харахад оюутнууд 1 ба 2-р курст маш олон хичээлээр онолын мэдлэг эзэмшиж байгаа хэдий ч ахлах курс хүртэл эдгээр онолын мэдлэгээ бараг хэрэглэхгүй байгаа учраас хоосон мэдлэгээс цаашгүй, практик ур чадваргүй төгсөгч гарах нөхцөл үүсдэг. Иймээс зураг 1.3-д үзүүлсэн байдлаар оюутан эхний курсээсээ эхлэн хичээлээр олж авсан мэдлэгээ төсөл, асуудал шийвэрлэх даалгавар гүйцэтгэх замаар практик ур чадвар болгох, улмаар хувь хүний болон харилцааны ур чадвар, хандлагыг эзэмших боломжтой байх ёстой.

**1-р курст** тухайн мэргэжлийн удиртгал хичээлийг заавал судлах, энэ хичээлийн асуудал шийдвэрлэх даалгавар, бичил төслийн хүрээнд дээд боловсролын суурь хичээлийн мэдлэгээ хэрэглээ болгох ёстой.

**2, 3-р курст** төслийн хичээл судлах замаар дээд боловсролын суурь болон мэргэжлийн суурь хичээлээр олж авсан мэдлэгээ хэрэглээ болгох боломж бүрдсэн байх ёстой. Мөн хичээлүүд өөр хоорондоо агуулга, суралцахуйн үр талаасаа нягт уялдсан байх хэрэгтэй.

**Ахлах курст** дадлага, дипломын төслөөр бие дааж асуудал шийдвэрлэх даалгавар гүйцэтгэх, бодит хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадвар эзэмших ёстой.

Оюутан ингэж шат дараалан төсөл, томоохон даалгавар гүйцэтгэх замаар суралцах хугацаанд олж авсан мэдлэгээ хэрэглэх ур чадвар эзэмшихээс гадна хандлага талын олон чадвараа хөгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн хөтөлбөрийг нийлмэл сургалтын хөтөлбөр хэмээн тодорхойлох боломжтой.



Зураг 1.3. Нийлмэл сургалтын хөтөлбөрийн бүтцийн загвар

Сургалтын хөтөлбөр ба хувь хүний ур чадвар, хандлага Сургалтын хөтөлбөрөөр оюутанд хувь хүний болон харилцааны хандлага, ур чадвар эзэмшүүлэхэд онцгой анхаарах ёстой.


✦ Уламжлалт хөтөлбөрт энэ асуудалд төдийлөн анхаардаггүй бөгөөд ихэвчлэн нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн цөөн хэдэн хичээлээр олгох ёстой гэж үздэг байсан.

✦ Нийлмэл сургалтын хөтөлбөрийн хувьд оюутнууд мэргэжлийн хичээлээр дамжуулан ур чадвар, хандлагаа хөгжүүлэх боломжтой байх шаардлагатай.

Зураг 1.4-д харуулсанчлан, суралцах хугацаа зүүнээс баруун чиглэлд өрнөхөд оюутанд мэдлэг, ур чадвар, хандлагыг хамтад нь эзэмшүүлэх 3 хувилбар байж болно. Үүнд:

- Шинжлэх ухааны мэдлэг давамгайлсан хувилбар
- ▣ Мэргэжлийн ур чадвар, хандлагыг голчлон хөгжүүлэх хувилбар
- ▢ Эдгээрийг тэнцвэртэй хөгжүүлэх хувилбар

Энэхүү аргачлал нь оюутны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг зэрэг хангах зорилготой юм.



**Зураг 1.4 Сургалтын хөтөлбөрийн бүтцийн хувилбар**

Суралцахуйн үр дүн ба ур чадвар эзэмшүүлэх загварууд

Оюутанд хувь хүний, хувь хүн хоорондын харилцааны болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадвар, хандлагыг эзэмшүүлэх нь сургалтын хөтөлбөрийн чухал зорилтуудын нэг юм. Үүнийг сургалтын төлөвлөгөөнд тусгах хэд хэдэн загвар байдаг:

(a) Нэгдмэл загвар

✦ Шинжлэх ухааны мэдлэг олгох хичээлүүдийн суралцахуйн үр дүнд хувь хүний ур чадвар, хандлагыг багтаан эзэмшүүлдэг.

✦ Энэ загвар нь мэргэжлийн чиглэлийн хичээлүүдэд ур чадвар, хандлага суулгахыг зорьдог бөгөөд хамгийн үр өгөөжтэй гэж үздэг.

(б) Нэгдмэл зэрэгцээ загвар

✦ Шинжлэх ухааны мэдлэг ба хувь хүний ур чадвар, хандлага нь тусдаа хичээлүүдээр зэрэг заагдана.

✦ Жишээ нь: Нэг улиралд техникийн хичээл үзэхийн зэрэгцээ багийн харилцаа, манлайллын хичээл судлах.

✦ Зураг 1.5-д үзүүлсэнчлэн, төсөлт хичээлүүд нь энэ загварыг хэрэгжүүлэх үр дүнтэй арга болдог.

✦ Эхлээд шинжлэх ухааны мэдлэгийг олгоод, дараа нь хувь хүний ур чадвар, хандлага хөгжүүлэх сургалт явуулна.

✦ Энэ загвар нь тусдаа үе шаттай боловч, оюутан суралцах явцдаа харилцааны болон мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх боломж хязгаарлагдмал байж болно.

💡 Шилдэг хувилбар

Эдгээр загварын аль алийг нь ашиглах боломжтой ч (а) Нэгдмэл загвар хамгийн үр дүнтэйд тооцогддог. Гол зорилго нь мэргэжлийн хичээлүүдээр дамжуулан ур чадвар, хандлага эзэмшүүлэхэд чиглэх явдал юм. Гэхдээ бүх загварыг хослуулан ашиглавал хамгийн үр дүнтэй сургалтын хөтөлбөр бий болох боломжтой.



**Зураг 1.5. Нийлмэл сургалтын хөтөлбөрөөр олон талт ур чадвар, хандлага олгох төлөвлөлтийн жишээ**

**Дүгнэлт**

Сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулах, шинэчлэхдээ нийлмэл сургалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж, түүний бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийн тодорхойлж, уялдаа холбоог нь сайтар гаргах нь чухал. Хэрэв энэ бүхнийг өндөр түвшинд гүйцэтгэвэл үр дүнд суурилсан боловсролын шаардлагад нийцсэн, үр өгөөжтэй сургалтын хөтөлбөр бий болох боломжтой. Үр дүнд суурилсан боловсролын зарчмаар сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд дараах чухал шаардлагууд тавигдана.

## Үндсэн шаардлагууд

✓ Технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, улс орны хөгжлийн бодлого

→ Сургалтын хөтөлбөр нь шилдэг технологийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, улс орны урт хугацааны бодлоготой уялдсан байх ёстой.

✓ Суралцахуйн үр дүн ба хичээлийн уялдаа

→ Хичээл бүрийн суралцахуйн үр дүнг сургалтын хөтөлбөрийн ерөнхий зорилттой нийцүүлэн, заах арга, үнэлгээний бодлоготой уялдуулж боловсруулах шаардлагатай.

✓ Суралцагч төвтэй сургалтын арга зүй

→ Суралцагчдын оюун бодол, идэвхтэй оролцоог дэмжих онол, арга зүйг бүх хичээлд нэвтрүүлэх хэрэгтэй.

✓ Үнэлгээ ба тасралтгүй сайжруулалт

→ Нэгж хичээлээс эхлээд хөтөлбөрийн түвшинд хүртэл суралцахуйн үр дүнг тогтмол үнэлж, тасралтгүй сайжруулах тогтолцоог бий болгох шаардлагатай.

✓ Оролцогч талуудын хамтын ажиллагаа

→ Ажил олгогчид, төгсөгчид, суралцагчид зэрэг оролцогч талуудыг хөтөлбөрийн төлөвлөлт, чанарын үнэлгээ, сайжруулалтын үйл ажиллагаанд байнга татан оролцуулах тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.

### Ашигласан ном хаяг:

1. Дээд боловсролын тухай Монгол улсын хууль
  2. Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /ROADMAR/ 2010-2021
  3. МУИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2010-2020.  
<http://www.num.edu.mn>.
- Карелина И.Г. Дээд боловсролын байгууллагууд ба боловсролын хөт